



ХААН БАНК

QRay Үйлчилгээ

Гарын авлага

QR кодоор
ТӨЛБӨРӨӨ ТӨЛДӨГ
БОЛЛОО

МОНГОЛД
АНХ УДАА



‘QRay үйлчилгээ’ гэж юу вэ?

ХААН Банкны интернет банкны харилцагч ‘Khan Bank’ ухаалаг аппликейшнаар дамжуулан QR /КЮ-АР/ код буюу 2 хэмжээт мэдээлэл хадгалах кодыг уншуулан төлбөр төлөх, өөрийн дансандаа QR код үүсгэх буюу нэхэмжлэх үүсгэж дансандаа орлого хүлээн авах боломжтой үйлчилгээ юм.

Яагаад ‘QRay үйлчилгээ’-г ашиглах төлөх вэ?

Дансны дугаар бичих шаардлагагүй



Гүйлгээний мэдээллийг нэг бүрчлэн шивэх шаардлагагүй тул данс, мөнгөн дүн бусад мэдээлэл буруу оруулах эрсдэлгүй

Ердөө 3 алхамаар төлнө



Орон зай, цаг хугацаанаас үл хамааран ердөө 3 алхамт хялбар байдлаар төлбөр төлөх, хүлээн авах боломж

НӨАТ-ын системд автоматаар бүртгэгдэнэ



Төрийн байгууллагын төлбөрийн нэхэмжлэлийг заавал банкны теллерт төлж, баримт авах шаардлагагүй бөгөөд НӨАТ-ын системд автоматаар бүртгэгдэнэ

Хэрхэн ‘QRay үйлчилгээ’-ний хэрэглэгч болох вэ?

Та ХААН Банкны Интернет банкны хэрэглэгч бол ‘Khan Bank’ ухаалаг аппликейшнаа ‘Update’ хийснээр ‘QRay үйлчилгээ’-г шууд ашиглах боломжтой. Хэрэв та интернет банкны хэрэглэгч биш бол ХААН Банкны өөрт ойр салбарт нэг л удаа ирж хүсэлтийн маягт бөглөн интернет банкны хэрэглэгч болоорой.

1. 'QRay үйлчилгээ'-г ухаалаг гар утсандаа суулгах

Алхам 1

ХААН Банкны 'Khan Bank' ухаалаг аппликейшнийг Play store/Android/, Apple store /iOS/-аас гар утсандаа татаж суулгана.

**Хэрэв 'Khan Bank' ухаалаг аппликейшинтай бол 'Update' хийж шинэчилснээр 'QRay үйлчилгээ' цэс шинээр нэмэгдэх юм.*

2.'QRay үйлчилгээ'-ний цэсний бүтэц

1. 'QRay үйлчилгээ' цэс

Шинэчлэгдсэн 'Khan Bank' ухаалаг аппликейшнд 'QRay үйлчилгээ' цэс дараах байдлаар харагдах ба нийт 4 функцтэй.



2. QR унших

Гар утасны камерыг ашиглах QR код уншигч гарч ирнэ.




3. QR зураг оруулах

Гар утсанд хадгалагдсан QR кодны зургийг уншуулж төлбөр төлөх, мөнгө шилжүүлэх боломжтой.




4. Төлбөрийн түүх

‘QPay үйлчилгээ’ цэсээр хийгдсэн болон ирээдүйд хийхээр хадгалсан төлбөрийн түүхүүд харагдана.



5. QR үүсгэх

Өөрийн дансанд QR код бүхий нэхэмжлэл үүсгэж бусдаас төлбөр цуглуулах боломжтой.



3. Өөрийн дансанд QR код үүсгэж орлого хүлээн авах


Алхам 1

QR код үүсгэх цэсийг сонгоно.



Алхам 2

Дансанд QR код үүсгэхийн тулд 10 оронтой дансны дугаар, нэвтрэх нууц үгээ оруулан нэвтрэлт хийнэ.




Алхам 3

+ товчийг дарж QR кодыг үүсгэнэ.



Алхам 4

Таны овог, нэр, данс автоматаар гарч ирэх тул данс андуурах эрсдэл үүсэхгүй. Нэхэмжлэх үнийн дүнг оруулж хадгалах товчийг дарна.




Алхам 5

Оруулсан мэдээллийн дагуу нэхэмжлэх QR код үүснэ.



Алхам 6

Үүссэн QR код дараах байдлаар харагдана. Үүсгэсэн QR кодоо бусад руу илгээж төлбөр цуглуулах юм. Дансны дугаараа өгөхгүй зөвхөн QR кодоо өгөөд орлого хүлээн авна.



4. Харилцагчийн үүсгэсэн QR кодын дагуу бусад харилцагч шилжүүлэг хийх


Алхам 1

Нэхэмжлэгчийн явуулсан QR кодын зургийг ‘QR зураг оруулах’ цэсийг сонгон гар утаснаасаа уншуулна.




Алхам 2

Нэхэмжлэгчийн QR кодыг уншуулснаар гарч ирэх дэлгэц дараах байдлаар харагдана. Мэдээллийг баталгаажуулсны дараа “Үргэлжлүүлэх” товчийг дарна.




Алхам 3

Гүйлгээний нууц үгээ оруулна.




Алхам 4

Гүйлгээ амжилттай хийгдсэн эсэх мэдээлэл гарч ирнэ.



Алхам 5


Төлбөрийн түүх цэсийг сонгон төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллээ харна.



5. НӨАТ-ын баримт авах


Алхам 1

Төлбөр төлсний дараа НӨАТ-ын баримт авах товчийг дарна.




Алхам 2

НӨАТ-ын буцаалтад автоматаар бүртгүүлэх мэдээллийг оруулж баримт авах товчийг дарна.



Алхам 3

Нэхэмжлэгч НӨАТ төлдөг эсэхээс шалтгаалан мэдээлэл гарч ирнэ.



6. СКАЙтелийн нэгж, дата авах


Алхам 1

QR унших цэсээр СКАЙтелийн QR кодыг уншуулна




Алхам 2

Нэгж, дата сонголтоо хийн худалдан авах товчийг дарна.




Алхам 3

Утасны дугаараа оруулан үргэлжлүүлэх товчийг дарна.




Алхам 4

Гүйлгээний нууц үгээ оруулна.




Алхам 5

Гүйлгээ амжилттай хийгдсэн эсэх талаар мэдээлэл гарч ирнэ.



Алхам 6


Төлбөрийн түүх цэсээс төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг харна.



7. Замын цагдаагийн газрын торгуулийн хуудас төлөх

Алхам 1

QR унших цэсээр торгуулийн хуудсын QR код уншуулна.




Алхам 2

Мэдээллээ баталгаажуулна.




Алхам 3

Шилжүүлэх дансаа сонгоно.




Алхам 4

Гүйлгээний нууц үгээ оруулна.



Алхам 5

Гүйлгээ амжилттай хийгдсэн эсэх талаар мэдээлэл гарч ирнэ.



Алхам 6

‘Энэ төлбөрийг байнга хүлээж авна’ сонголтыг идэвхжүүлснээр тухайн Регистрийн дугаар дээр үүсгэгдсэн торгуулийн хуудсыг автоматаар “Ухаалаг банк”-нд хүлээн авна.

